



УРИАЛГА

Монголын нийт ард түмэндээ 2012 он - “Олон улсын хоршооллын жил”-ийн мэндчилгээг дэвшүүлж, аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөе.

Амжилт бүтээлээр дүүрэн 2011 он улиран одож, 2012 он айлчлан ирж Дэлхий дахинаа “Олон улсын хоршооллын жил” эхэлж байна. Хоршоолсон аж ахуйн давуу тал, бизнес эрхлэх өвөрмөц хэлбэрийг дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрч НҮБ-ын 2009 оны 64 дүгээр Ерөнхий Ассамблейгаас 2012 оныг “Олон улсын хоршооллын жил” болгон зарлах болсноор хоршооллын байгууллагуудыг сурталчлан дэмжсэн олон чухал ажил өрнөж байна. Хоршооллын жилийг санаачлагч орны хувьд Монгол улсын төр засаг, Монголын хоршоологчдын манлайлал, оролцоо нэн чухал билээ.

Монголын хоршоодын мэргэжлийн холбоодоос Монгол Улсын Их Хурал, Засгийн газар болон бүх шатны Засаг дарга, хоршоологчиддоо хандан доорх уриалгыг гаргаж байна.

1. **Монгол Улсын Их Хуралд:**

- Хоршооны хууль эрх зүйн орчинг шинэчлэн сайжруулах ажлыг шуурхай хэрэгжүүлэх

2. **Монгол Улсын Засгийн газарт:**

- Хоршоог дэмжсэн бизнесийн болон татварын таатай орчинг бүрдүүлэх
- Хоршооллын салбарт хамааралтай төрийн зарим чиг үүргийг хоршоодын мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх
- Хоршоонд чиглэсэн төсөл хөтөлбөр, зээл санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх
- Хоршоог бойжуулах төрөлжсөн инкубацийн үйлчилгээг бий болгоход дэмжлэг үзүүлэх

3. **Бүх шатны Засаг дарга нарт:**

- Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийн салбар зөвлөлийн даргын хувьд тухайн аймгийн хоршоодын холбоо, сумдын хоршоодыг хууль, эрх зүйн хүрээнд дэмжиж, үр бүтээлтэй хамтран ажиллах
- Аймаг, сумдад төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авч буй бараа ажил үйлчилгээг болон төрийн зарим чиг үүргийг хоршоодын холбоо, хоршоодоор гүйцэтгүүлэх
- ХАА-н биржийн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор орон нутагт түүхий эд бэлтгэл, борлуулалтын хоршоодыг дэмжиж, сургалт сурталчилгааг өргөнөөр зохион байгуулах

4. Хоршоологчдод:

- Дэлхий нийтээрээ хоршоог дэмжсэн ажил өрнүүлж байгаа энэ үед хоршоологчид өөрсдөө овсгоо санаачлагатай ажиллаж, боловсон хүчнийхээ мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хоршооны гишүүдээ дэмжих чиглэлээр үр дүнтэй ажиллах
- Хоршоо бүр нийгмийн өмнө хүлээсэн үүргээ ухамсарлаж, өөрийн орон нутгийн болон хоршооны түвшинд бүтээлч ажил санаачлан хэрэгжүүлэх
- Орон нутгийн болон гишүүдийнхээ эрэлт хэрэгцээ, нөөцөд тулгуурлан жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэлтийг нэмэгдүүлэх
- Хоршооны Олон улсын зарчмыг мөрдөж ажиллах зэрэг асуудлуудыг шийдвэрлэж, ажил хэрэг болгох талаар бүх шатанд анхаарч ажиллахыг уриалж байна.


Монгол оронд хоршооллын хөдөлгөөнийг хөгжүүлэх, хоршоодын эгнээг өргөжүүлж, хөгжлийн шинэ шатанд гаргахад хоршоодын мэргэжлийн холбоодын зүгээс Та бүхэнтэй бүх талаар хамтран ажиллах болно.

Монголын Хоршооллын Үндэсний
Нэгдсэн Холбооны тэргүүн



[Handwritten signature]

Монголын Хөдөө Аж Ахуйн
Хоршоологчдын Үндэсний Холбооны
ерөнхийлөгч Н.Баяртсайхан



[Handwritten signature]

Монголын Худалдаа, Эд Хэрэглэгчдийн
Хоршооллын Төв Холбооны дарга
М.Эрдэнэтуяа



[Handwritten signature]

Монголын Үйлдвэрлэлийн Хоршооллын
Төв Холбооны Ерөнхийлөгч
Ф.Алтангааяа



[Handwritten signature]

Монголын Үйлдвэрлэл Үйлчилгээний
Хоршоодын Холбооны ерөнхийлөгч
С.Энхтуяа



[Handwritten signature]

Монголын Хадгаламж Зээлийн Хоршоодын
Холбооны тэргүүн
Ш.Гоохуу



[Handwritten signature]

Монголын Хоршооллын Сургалт
Мэдээллийн Төвийн гүйцэтгэх захирал
Ц.Мягмар-Очир



[Handwritten signature]